

“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 12-р сарын 09-ны өдөр

Улаанбаатар хот

“Фронтинер Лэнд Групп” ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Бус Хурлыг 2019 оны 12-р сарын 09-нд Улаанбаатар хотод зарлан хуралдуулав. Хурал Пума Импераил Зочид Буудлын 2 давхрын хурлын ВИП-1 зааланд хурлын ирц бүрдсэний үндсэн дээр дэгийн дагуу 15 цаг 10 минутанд эхлэв.

Хурлын ирц 11,868,539 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл буюу 86,4%-д хүрч хурал хүчин төгөлдөр эхлэх болсоныг Хурлын Тооллогын Комиссын Дарга С. Шижиртуяа танилцуулав.

Хурлын ирц бүрдсэн тул хурлын дарга О. Амартүвшин хурлыг нээн, хурлын дэг, компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулсан ба хуралд оролцогсод асуудлуудаа хэлэлцэж явж байгаад санал асуулгаа авахаар тохиров.

Хурлаар хэлэлцсэн асуудлын жагсаалт:

1. Компанийн үйл ажиллагааны чиглэл, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах
2. Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн батлах
3. Их хэмжээний болон Сонирхолын зөрчилтэй хэлцэл батлах
4. Компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авах тухай
5. Шаардах эрх хэрэгжүүлэх тухай
6. Бусад.

Фронтинер лэнд группын захирал О. Амартүвшин: За манай Фронтинер лэндгруппын хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал эхэлснийг мэдэгдэе. Бид ээлжит бус хурал зарлах болсон нь дараах шалтгаантай. Нэгдүгээр шалтгаан нь манай компанийн үндсэн үйл ажиллагаа нь үл хөдлөх хөрөнгийн борлуулалт, түрээслэх зэрэг байгаа. Гэвч сүүлийн жилүүдэд үл хөдлөх хөрөнгийн зах зээл дээрх манай хөрөнгийн өрсөлдөх чадвар буурч байна учир нь энэ чиглэлийн мэргэжлийн компаниуд нэмэгдсэнээр өрсөлдөөн өссөн мөн урьд барилга баригдсанаар манай байршил нүүрний эгнээний байршил биш болсон үнэлгээ болон үйл ажиллагаанд шууд нөлөөлж байна. Иймд бид компанийн үйл ажиллагаанд зайлшгүй өөрчлөлт оруулах хэрэгтэй юм байна гэж үзсэн.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал дээр үйл ажиллагаа явуулж буй салбартай холбоотой бидэнд учирч буй бэрхшээл мөн гарч болох эрсдэлүүдийг ярилцсаны үндсэн дээр үндсэн үйл ажиллагааг өөрчлөн зохион байгуулах шаардлагатайг тогтсон.

Бид ирэх онд компанийн үйл ажиллагаанд нэвтрүүлж болохуйц Мэдээллийн Технологитой холбоотой дараах үйлчилгээнүүдийг үндсэн үйл ажиллагаа болгохоор харж байна.

- Мэдээллийн технологийн стратеги боловсруулах
- Мэдээллийн технологийн төслийн удирдлага
- Системийн нэвтрүүлэлтийг удирдан хэрэгжүүлэх, өөрчлөлтийн удирдлага ба сургалт
- Их өгөгдөл боловсруулах, хүнд ойлгомжтойгоор түгээх үйлчилгээ
- Мэдээллийн аудит, аюулгүй байдлын зөвлөгөө, үнэлгээ
- Системийн интеграцичлал, системийн архитектур, шийдлийн зөвлөгөө

- Өгөгдлийг үүлэн орчинд хадгалах, үүлэн орчны үйлчилгээ
- Хиймэл оюун ухааны шийдлийн нэвтрүүлэлт
- Криптовалют, цахим мөнгө түүнтэй холбоотой арилжаа болон сургалт
- Шинэ систем хөгжүүлэлт, нэвтрүүлэлт
- Эвэнт менежмент

Хоёрдугаар асуудал нь 2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний санал, Үүнд дараах үйл ажиллагаанууд багтаж байгаа:

1. Мэдээллийн технологийн зөвлөх үйлчилгээ
2. Мэдээллийн технологийн аудит
Сүүлийн үед олон тооны шинэ систем платформууд хөгжүүлэгдэн гарч мөн гадны системүүд эрчимтэй нэвтэрч байна. Мөн олон тооны системийн шийдэл хөгжүүлэгч компаниудтай боллоо. Гэвч эдгээр системийг мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хангаж буй, байгууллагад үнэ цэнэ бүрдүүлж байна уу үгүй юу, автоматжуулалтын түвшин хангалттай юу зэрэг дээр үнэлэх, хөндлөнгийн хяналт тавих үйлчилгээ дутмаг хомс байна. Энэхүү орон зайд шинэ үйлчилгээ эхлэхийг зорьж байна.
3. Сургалт
Хоёрдугаар давхрын түрээслэгдээгүй удаж буй хойшоо харсан цонхтой өрөөнүүдийг сургалтын зориулалтаар ашиглаж болохоор байгаа. Энэ тал дээр бид судалж байна.
4. Бараа захиалгын платформ
Бараа захиалга, онлайн дэлгүүрийн өөрийн онцлог бүхий шийдлийг бид багара хэлэлцэж байгаа. Энэ ондоо багтаан эхлүүлэхийг зорьж байна.
5. Аялал жуулчлалын салбарт зориулсан захиалгын систем
Тур оператор болон гэр кэмп, буудлуудыг холбосон B2B шийдэл байх юм. Аялал жуулчлалын салбарт олон төрлийн ийм систем байдаг ч бизнесийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сайн систем алга байна. Бид энэ системийг үүсгэе гэж ажиллана.

Эдгээр нь аль болох өөрсдийн нөөц боломжид түшиглэсэн, бага нөөц, эх үүсвэрээр хурдан хугацаанд хэрэгжүүлж болох үйл ажиллагаанууд юм. Үйл ажиллагааны чиглэл болон 2020 оны төлөвлөгөөтэй холбоотой асууж тодруулах зүйл байна уу? (*Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт гарсангүй*)

БИ ДИ СЕК ҮЦК-ийн дэд захирал Б. Лхагвадорж: Асууж тодруулах зүйлээ хурлын төгсгөлд хийж болох уу?

Фронтнер лэнд группын захирал О. Амартүвшин: санал нэг байна. За тэгвэл үргэлжлүүлээд 3 дахь хэлэлцэх асуудалаа хэлэлцэе. Энэ нь их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлэлцэн батлах тухай юм. Би Ди Сек компани 2,095,891 ширхэг хувьцааг эргүүлж худалдах санал бидэнд тавьсан. Компанийн зүгээс ТУЗ –ийн хурлаар тус асуудлыг хэлэлцэж үзээд эргүүлэн худалдаж авах боломжтой юм гэж тогтсон. Гэхдээ бусад хувьцаа эзэмшигчдийн, ялангуяа жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг ханган ажиллахыг ТУЗ-ийн дарга Оюунболд үүрэг болгосон. Энэхүү асуудал нь хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал юм.

БИ ДИ СЕК ҮЦК-ийн дэд захирал Б. Лхагвадорж: БИ ДИ СЕК компанийг төлөөлж байгаа дэд захирал Лхагвадорж гэж хүн байна. Манай компани одоогоор МДР буюу Фронтнер Лэнд Группын 15 хувийг эзэмшиж байгаа. Тус компанид эзэмшиж байгаа компанийн үл хөдлөх хөрөнгө нэлээн өндөр үнэлгээтэй байгаа харагдсан. Манай компани өөрсдөө хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулдгын хувьд хөрөнгөө төлөвлөсөн хугацаандаа суллаж аваад дараа дараагийн зүйлд хөрөнгө оруулдаг стратеги баримтлан ажилладаг. Манайх Фронтнер лэнд группын хувьцааг нь аваад нэлээн удаан эзэмшсэн байдалтай байгаа. Компанийн зүгээс хувьцааг одооны зах зээлийн үнээр эргэн худалдан авахад Фронтнер группэд илүү ашигтай байж болох юм байна гэж бодож байна. Реженси Ресиденсийн үл хөдлөх хөрөнгө болон төслийн 17 га газар гээд үзвэл нэлээн үнэ цэнэтэй компани. Энэ компанийн эзэмшиж байгаа үл хөдлөх хөрөнгүүд нь компанийн

одоогийн байгаа зах зээлийн үнээс нэлээн өндөр үнэлгээтэй байж болох юм байна гэсэн үүднээс компанид хувьцаагаа эргүүлж худалдан авах санал тавьсан. Боллоцотой бол манай хувьцааг эргүүлж худалдан авах талаар бодолцож үзээч ээ. Миний ойлгосноор ТУЗ болон том хувьцаа эзэмшигчид өөрсдөө тооцоо хийж үзсэн байх. Манай хувьцааг худалдаж авахад болохгүй зүйл байхгүй боловч хуулийнхаа дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдэх ёстой учир энэ хүрлийг зохион байгуулж байгаа гэж ойлгож байгаа. Мөн бусад хувьцаа эзэмшигчдэд шаардах эрхийг хэрэгжүүлэх үүднээс ТУЗ – аас тогтоол гаргаад хуралд оролцуулсан байсан.

Евразиа Капитал Холдинг ҮЦК-ийн захирал, Фронтинер Лэнд Групп ТУЗ-ийн дарга Оюунболд: Бусад гэдэг дээр дараах зүйлийг тодруулах хэрэгтэй байх. БИ ДИ СЕК буцааж худалдаж авах хүсэлт гаргасан боловч компанид мөнгө байхгүй байгаа тийм үү.

Фронтинер Лэнд Группын захирал О. Амартүвшин: Тийм.

Евразиа Капитал Холдинг ҮЦК-ийн захирал, Фронтинер Лэнд Групп ТУЗ-ийн дарга Оюунболд: Компани нь үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт оруулаад танай хуучин үл хөдлөх хөрөнгө болих нь байна. Мөн БИ ДИ СЕК болон бусад хүсэлт гаргасан хүмүүсийн хувьцааг худалдан авахад мөнгө хэрэг болох учир танайх үл хөдлөх хөрөнгөө зарах шаардлагатай болох нь. Миний харж байгаагаар мэдээж аль ч компани хуулиараа эргүүлэн худалдан авах санал тавих эрхтэй. Мөн компани энийг худалдаж авсны дараа төлбөрийн чадвартай үлдэж байх ёстой. Энэ хүсэлтүүдийг ганц БИ ДИ СЕК биш бусад хувьцаа эзэмшигчид гаргахад бид хүлээн авч таарна. Энэ хувьцааг худалдан авахад та нар объектуудаа л зарах хэрэг гарна. Тэгэхээр бусад гэдэг зүйл дээр объект худалдах, хөрөнгөнүүдээсээ буцаж худалдах гэх зүйл оруулах ёстой юм болов уу.

Фронтинер Лэнд Группын захирал О. Амартүвшин: Оюунболд захиралын ярьж байгаа асуудлыг би их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй батлах гэдэг дээр хоёрдугаар зүйл болгон оруулсан байгаа. Оюунболд захирлын ярьсан шинээр үйл ажиллагаа явуулахад зардал гарах бөгөөд өөрсдөө Мэдээллийн технологийн хүн хүч бүрдүүлэх буюу IT баг суулгахад мэдээж зардал өндөр гарна. Тийм учир бусад багтай хамтрах гэх мэт зардал багатай арга зам хайж байгаа. Ямар ч байсан зардал гарах учир бид одоо ашиглаагүй байгаа талбайгаа зараад эхэлсэн дээр болов уу гэж бодож байна. Мөн үл хөдлөх хөрөнгийн салбар дээрхи манай хөрөнгийн өрсөлдөх чадвар муудаж байгаа учир үнэнд нөлөөлөхөөс өмнө зарсан дээр болов уу гэсэн байр суурьтай байна. Оюунболд захирлын ярьсан үл хөдлөх хөрөнгө зарж борлуулах тухай хэлцлээ их хэмжээний хэлцэл буюу 3 зүйл дээр оруулсан байгаа. Мөн компани нь өөр хүмүүсийн хувьцааг худалдан аваад халааслахад компанид болон жижиг хувьцаа эзэмшигчдэд мөн ашигтай байж болох хувилбар харагдаж байгаа. Ингээд шат дараатай явсан тохиолдолд манай компани цаашид үйл ажиллагаа өргөжин хувьцааны үнэ өсөж жижиг хувьцаа эзэмшигчдэд ашигтай байхаар харагдаж байна.

Хувьцаа эзэмшигч Д.Энхтуяа: Надад нэг асуух зүйл байна. Мэдээлэл технологийн, дижитал үйл ажиллагаа явуулна гэж байгаа. Гэвч хаана явуулна гэж төлөвлөж байгаа вэ? Мөн компанийн үл хөдлөх хөрөнгө болон сургалт явуулах газруудын талаар дэлгэцээр үзүүлэх боломж байна уу.

Фронтинер Лэнд Группын захирал О. Амартүвшин: Реженси дээр манай удаан хугацаанд түрээслэгдээгүй байгаа хоосон талбайнууд байгаа. Тэнд хийх төлөвлөгөөтэй байна. За ойлголоо таны саналыг хүлээж авлаа, хавар ээлжит хурлын үеэр тэгж харуулъя. /Прожектор руу холбох залгуурын оролт таараагүй, утсан дээрээс үл хөдлөх хөрөнгийн зургийн хайж харуулав./. За өөр асуух асуулт байхгүй бол санал хураалтаа эхлүүлэх үү?

Евразиа Капитал Холдинг ҮЦК-ийн захирал, Фронтинер Лэнд Групп ТУЗ-ийн дарга Г. Оюунболд: Одоо та хэд зөвшөөрөх юм бол журамаа батлах хэрэгтэй болно.

Хувьцаа эзэмшигч Б. Цэрэнжав: Компани одоо БИ ДИ СЕК ийн хувьцааг худалдан авахад хэдийн хэмжээний хөрөнгө хэрэг болох вэ?

Фронттиер Лэнд Группын захирал О. Амартүвшин: Нэгж хувьцааг 300 төгрөг.

БИ ДИ СЕК ҮЦК-ийн дэд захирал Б. Лхагвадорж: Харин тиймээ, зах зээлийн үнэтэй тун ойр үнэ. Сүүлийн өдрийн хаалтын ханш 291 төгрөг байсан.

БИ ДИ СЕК ҮЦК-ийн дэд захирал Б. Лхагвадорж: Би Реженсиг үзэж байсан 1 – 2 давхар дээр үйл ажиллагаа явуулж байна лээ. 3 давхарт мөн байсан уу? Урд нь зүгээр байсан гэвч намайг очиход урд талд нь байр бариад хаасан байсан. Тиймээс түрээслэгчдийн сонирхол бага болсон гэж ойлгож байгаа.

Фронттиер Лэнд Группын захирал О. Амартүвшин: За санал хураалтаа эхлүүлэх үү?

Ийнхүү хурлаар хэлэлцэх бүх асуудлуудыг хэлэлцэж нэмэлт тодруулга хийсний дараа хурлын дэгийн дагуу Тооллогын комиссын дарга саналын хуудас бөглөх зааварчилгаа, тооллогын журмыг танилцуулаад Хурал зохион байгуулах бүрэлдэхүүн хуралд итгэмжлэлтэй ирсэн хувьцаа эзэмшигчдээс холбогдох журмын дагуу саналын худсыг хураан авч тоолов.

Саналын хуудсуудыг нягтлан шалгаж, тооллогын нэгтгэсэн дүнг Тооллогын Комиссын дарга С. Шижиртуяа хувьцаа эзэмшигчдэд уншиж танилцуулав.

Санал хураалтанд Компанийн нийт гаргасан 13,750,000 хувьцаанаас халаасны хувьцааг хассан саналын эрх бүхийн нийт 13,744,342 хувьцаанаас 11,868,539 ширхэг хувьцаа буюу 86.4 хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид хурлаар хэлэлцэх 6 асуудлаар өгсөн саналын үр дүн дараах байдлаар гарсаныг С. Шижиртуяа мэдэгдэв:

№	Хэлэлцэх асуудлын жагсаалт	Зөвшөөрсөн дүн	Татгалзсан дүн	Түгэлзсэн дүн	Зөвшөөрсөн хувь	Татгалзсан хувь	Түгэлзсэн хувь
1	Компанийн үйл ажиллагааны чиглэл, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах:	9,772,648	2,095,891	0	82.34%	17.66%	0
2	Компанийн цаашид, 2019-2020 оны Компанийн бизнес төлөвлөгөөг батлах:	9,772,648	2,095,891	0	82.34%	17.66%	0
3	Компанийн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах:	9,772,648	2,095,891	0	82.34%	17.66%	0
4	Компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авах тухай:	9,772,648	2,095,891	0	82.34%	17.66%	0
5	Шаардах эрх хэрэгжүүлэх тухай:	9,772,648	2,095,891	0	82.34%	17.66%	0
6	Бусад (асуудал хэлэлцээгүй болно)	9,772,648	2,095,891	0	82.34%	17.66%	0

Хурлын дарга хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулан, хурал өндөрлөсөныг 16 цаг 40 зарлалаа.

ХЯНАСАН

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН



О. АМАРТҮВШИН /ХУРЛЫН ДАРГА/

У. АНАР

/ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА/